



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Монгео” ХК-ийн дүрмийн 6.7 дахь заалт, Хувь Нийлүүлэгчдийн 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хуралд оролцсон Хувь Нийлүүлэгчдийн санал нэгтэй баталсныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ :

Нэг . Компанийн 2021 оны санхүүгийн тайланг зөвшөөрөхөөр шийдвэрлэсүгэй.

Хоёр . Компанийн үйл ажиллагааны тайланг зөвшөөрсүгэй.

Гурав . Аудиторын дүгнэлтийг хүлээн авсугай.

Дөрөв . Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхтэй оролцох, шаардагдах төсөв төлөвлөгөөг тооцож тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Тав . Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх , бизнес төлөвлөгөө, төслийг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

Зургаа . Компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 8,08 га газрыг Хүнс, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон, бусад зорилгоор ашиглах төсөл хэрэгжүүлэх ажлыг тодорхой үе шаттайгаар эхлүүлэхийг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Хурлын дарга /Н.Соёмбо /

Хурлын нарийн бичгийн дарга Э.Норовринчин /





**“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ШИЙДВЭР**

2020 оны 7 -р сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР :

Хувь Нийлүүлэгчдийн 2021 оны ээлжит хурлын саналын хуудасны тоог үндэслэн хэлэлцэх асуудал бүрийг саналын тоогоор батлав.

Тооллогын комиссын дарга  Ш.Алтанцэцэг /

Гишүүд :  / Ш.Амармэнд /

 /Ц.Оюунцэцэг /